

  

ТОМООР МӨРӨӨД БУЯНАА МИНЬ





БУЯНАА БОЛ ЦОНДОЙСОН ГЭДЭС, МАЙГАДУУ ХӨЛТЭЙ, БОЛХИДУУХАН



ХАРАГДДАГ БЯЦХАН ОХИН ЮМ. ГЭХДЭЭ ТҮҮНД ОД



БОЛНО ГЭСЭН МАШ ТОМ МӨРӨӨДӨЛ БАЙДАГ БИЛЭЭ.





БУЯНАА ДАНДАА Л БАЛЕТЫН БҮЖИГЧИН БОЛОХЫГ МӨРӨӨДДӨГ БАЙВ.



БҮР АЛДАРТАЙ БАЛЕТ БОЛОХ "ХУНТ НУУР" БҮЖГИЙН ЖҮЖИГТ ТОГЛОХООР



ХИЧЭЭЖ БАЙЛАА ДААНЧ ТЭР ХАНГАЛТТАЙ УЯН ХАТАН БИШ БАЙВ.



ЯГ ҮНЭНДЭЭ БУЯНАА ТҮН БОЛХИ БАЙЛАА.



ОХИНДОО ХАМГААС ИЛҮҮ ХАЙРТАЙ ЭЭЖ НЬ ТҮҮНД "МӨРӨӨДЛӨӨ ДАГА"
ГЭЖ ҮРГЭЛЖ ЗОРИГЖУУЛДАГ БАЙВ. ТҮҮНИЙ ХАМГИЙН ТОМ ШҮТЭН
БИШРЭГЧИД БОЛОХ ӨВӨӨ ЭМЭЭ НЬ "ЧИ ЧАДНА АА" ГЭЖ ДЭМЖИНЭ. БАС ХАМГИЙН
САЙН НАЙЗ ЦАЦРАЛ НЬ "ТОМ МӨРӨӨД, БУЯНАА МИНЬ" ГЭЭД БУЯНААГИЙН ДЭРГЭД
ҮРГЭЛЖ ХАМТ БАЙДАГ БАЙВ. ХАРИН БАЛЕТЫГ УДИРДАЖ БАЙСАН ХҮМҮҮС
Л "БУЖИГЛЭХ НЬ ЧИНИЙ ХИЙХ ЗҮЙЛ БИШ ЮМ БАЙНА. ӨӨР ЗҮЙЛ
ОРОЛДООД ҮЗЭЭРЭЙ" ГЭЖ ХЭЛЭХ НЬ ТЭР.



ИНГЭЭД БУЯНАА МААНЬ “ОДОД ДУУЛЖ БАЙНА” ГЭДЭГ АЛДАРТАЙ ДУУНЫ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ ҮЗЭХЭЭР ШИЙДЭВ. ТЭР ҮРГЭЛЖ СЭТГЭЛ ТАТАМ ДУУЧИН БОЛОХЫГ МӨРӨӨДДӨГ БАЙСАН ЮМ. ХАРИН ХАРАМСАЛТАЙ НЬ БУЯНАА ДУУГАА ДУУЛАХДАА АЯЫГ НЬ Ч ЗӨВ АЯЛАЖ ЧАДАХГҮЙ БАЙЛАА.



"МӨРӨӨДЛӨӨ ДАГА" ГЭЖ ЭЭЖ НЬ ТҮҮНИЙГ ЗОРИГЖУУЛСААР БАЙВ. "ЧИ ЧАДНА АА" ГЭЖ ӨВӨӨ ЭМЭЭ НЬ Ч ДЭМЖСЭН ХЭВЭЭР. "ТОМ МӨРӨӨД, БУЯНАА МИНЬ" ГЭЭД ЦАЦРАЛ Ч МӨН ХАЖУУД НЬ ХАМТ БАЙЛАА. ХАРИН ДУУНЫ ТЭМЦЭЭНИЙГ УДИРДАЖ БАЙСАН ХҮМҮҮС Л "ДУУЛАХ ЧАМД ТОХИРОХГҮЙ ЮМ БАЙНА" ТИЙМЭЭС ӨӨР ЗҮЙЛ ОРОЛДОЖ ҮЗСЭН НЬ ДЭЭР БАЙХ" ГЭЖ ХЭЛЭВ.



ДАРАА НЬ БУЯНАА МААНЬ СУПЕРМОДЕЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХООР БОЛЛОО. АЛДАРТАЙ СУПЕРМОДЕЛ БОЛОХ НЬ БАС Л ТҮҮНИЙ МӨРӨӨДӨЛ БАЙВ. ГЭТЭЛ БУЯНАА ТИЙМ Ч ГЯЛАЛЗСАН ДЭГЖИН БАЙЖ ЧАДААГҮЙГЭЭР БАРАХГҮЙ БҮР ӨМССӨН ДААШИНЗДАА БҮДЭРЧ УНАЛАА.



"МӨРӨӨДЛӨӨ ДАГА" ГЭЖ ЭЭЖ НЬ ТҮҮНИЙГ ЗОРИГЖУУЛАХАА БОЛЬСОНГҮЙ.

"ЧИ ЧАДНА АА" ГЭЖ ӨВӨӨ ЭМЭЭ НЬ Ч ДЭМЖСЭЭР БАЙЛАА. "ТОМ МӨРӨӨД,

БУЯНАА МИНЬ" ГЭЭД ЦАЦРАЛ Ч МӨН ХАЖУУД НЬ ҮРГЭЛЖ ХАМТ БАЙВ.

ХАРИН СУПЕРМОДЕЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

"ЗАГВАР ҮЗҮҮЛЭХ ЧАМД ТОХИРОХГҮЙ ЮМ БАЙНА. ӨӨР ЗҮЙЛ ОРОЛДООД

ҮЗВЭЛ ДЭЭР БАЙХАА" ГЭЖ ХЭЛЛЭЭ.



 ГЭВЧ ЭНЭ  БҮХ  БҮТЭЛГҮЙТЛИЙН  ДАРАА БУЯНАА  ӨӨР  ЮУ

 ОРОЛДОХОО  МЭДЭХГҮЙ  БАЙВ.  ТЭР  ХОТЫН  ГУДАМЖААР  АЛХАХДАА

ҮНЭХЭЭР  МӨРӨӨДӨЛДӨӨ  ХҮРЖ  ЧАДАХ ЭСЭХЭЭ  БОДОЖ  ЭХЭЛЛЭЭ.



БУЯНАА БУУЖ ӨГӨХИЙН ДАВААН ДЭЭР "ЗҮГЭЭР Л СЭТГЭЛ ЗҮРХЭЭ ДАГА.

ЮУ Ч БОЛСОН БИД ЧАМД ХАЙРТАЙ ГЭДГИЙГ САНААРАЙ" ГЭСЭН

ЭЭЖИЙНХЭЭ ҮГИЙГ, "БИД ЧИНИЙХЭЭ ХАМГИЙН ТОМ ШҮТЭН

БИШРЭГЧИД ШҮҮ!", ГЭСЭН ӨВӨӨ ЭМЭЭГИЙНХЭЭ ҮГИЙГ, МӨН

"БИД ЧИНИЙ ТӨЛӨӨ БАЙСААР БАЙХ БОЛНО" ГЭСЭН САЙН НАЙЗ



ЦАЦРАЛЫНХАА ҮГИЙГ САНАВ. БУЯНАА ИНЭЭМСЭГЛЭЖ ЭХЛЭВ.

УЧИР НЬ ТЭР ОДОО ЮУ ХИЙХЭЭ МАШ САЙН МЭДЭЖ БАЙЛАА!

БУЯНАА ӨӨРИЙН ХАМГИЙН ҮНЭТЭЙ ЗҮЙЛ БОЛОХ ХАЙРТАЙ ХҮМҮҮСИЙНХЭЭ

ТӨЛӨӨ ӨӨРТӨӨ ШИНЭ МӨРӨӨДӨЛ ОЛОХООР ШИЙДЭВ. ИНГЭЭД МАРГААШ НЬ

БУЯНАА ЦАЦРАЛИЙГ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГЭЭР ХАМТ ЗУГААЛАЯ ГЭЖ УРЬЖЭЭ.





ТЭД ХАМТДАА ХӨГЖИЛДӨН ЗУГААЛЖ БАЙХДАА МӨСӨН ГУЛГУУРЫН




ТАЛБАЙГ ОЛЖ ХАРЛАА. БУЯНАА, ЦАЦРАЛ ХОЁР МӨСӨН ДЭЭГҮҮР



ЭРГЭЛДЭН ГУЛГАЖ, ҮСРЭН БУУЖ БУЙ ГУЛГАГЧДЫГ ХАРЖ ХЭСЭГ БАЙВ.



ЭНЭ БОЛ ТҮҮНИЙ ӨМНӨ НЬ ОГТ ХАРЖ БАЙГААГҮЙ ХАМГИЙН САЙХАН




ЗҮЙЛ ГЭДГИЙГ БУЯНАА ШУУД Л ОЙЛГОЛОО. ЭНЭ ҮЕД ТҮҮНИЙ ЗҮРХ БАЯР



ХӨӨРӨӨР ДҮҮРЭЭД ИРЭВ. ЦАЦРАЛ Ч БУЯНААГИЙН НҮД НЬ ГЭРЭЛТЭХИЙГ

ХАРААД ТЭД ГАРАА ЦОХИЛЦОВ. "БУЯНАА МИНЬ, ТОМ МӨРӨӨД" ГЭЖ ЦАЦРАЛ

ТҮҮНИЙГ ДЭМЖЛЭЭ. ИНГЭЭД БУЯНАА ИНЭЭМСЭГЛЭСЭЭР МӨСӨН ТАЛБАЙН

БАГШ РУУ ОЧИЖ "БИ УРАН ГУЛГАЛТЫН ГАЙХАЛТАЙ ОД

БОЛМООР БАЙНА" ГЭЖ ХЭЛЭВ.



МӨСӨН ТАЛБАЙ ДЭЭР ЧИ БАЙЖ БОЛНО ГЭЖ ҮҮ? ХЭМЭЭН БАГШ

ХЭСЭГХЭН БОДОВ. "ХОНГОР МИНЬ, ҮҮНИЙГ БОЛОМЖТОЙ ЭСЭХИЙГ

БИ ХЭЛЖ МЭДЭХГҮЙ Л БАЙНА" ГЭХЭД “БОЛОМЖГҮЙ ЗҮЙЛ ГЭЖ

БАЙХГҮЙ ЭЭ. БИ МӨРӨӨДӨЛД ИТГЭДЭГ" ГЭЖ БУЯНАА ХАРИУЛАВ.






ЭНЭ ҮГИЙГ СОНССОН БАГШ МӨРӨӨ ХАВЧСАНАА, "ТЭГВЭЛ ЧИНИЙХЭЭР



Л БОЛОГ. "ЧАМАЙГ ЮУ ЧАДАХЫГ ХАРЦГААЯ" ГЭЖ ХЭЛЭХ НЬ ТЭР. БУЯНАА



ТЭШҮҮРЭЭ ӨМСӨН ҮДЭЭСЭЭ САЙТАР ҮДЭЭД МӨСӨН ДЭЭР



ГАРАХАД ТЭНЦВЭРЭЭ ОЛОЛГҮЙ ХАЛЬТАРЧ УНАВ ГЭХДЭЭ, ЭНЭ УДАА ...





БУЯНАА ЭРГЭЖ БОСЛОО. ТЭР ЭРГЭЛДЭЖ, БҮДЭРЧ



ХАЛЬТАРЧ УНАСАН Ч ДАХИН ДАХИН ОРОЛДОХОО БОЛЬСОНГҮЙ...



ИНГЭСЭЭР МӨСӨН ГУЛГУУРЫН ТАЛБАЙН ХААХ ЦАГ БОЛОХОД



   

БУЯНАА УНАХААСАА ИЛҮҮТЭЙГЭЭР ГУЛГАЖ БАЙВ.

 

ЭНЭ БҮХЭН ТҮҮНД ҮНЭХЭЭР Л ...

 

ИД ШИДИЙН МЭТ ... САНАГДСАН БИЛЭЭ.